



ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ПРОТОКОЛ

ХУРАЛДСАН ГАЗАР: Хан-Уул дүүрэг, 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоот

ХУРАЛ ҮРГЭЛЖИЛСЭН ХУГАЦАА: 10:00-11:00

ХУРАЛД ОРОЛЦСОН:

YEN MONTGOMER /89.6% хувьцаа эзэмшигч // эчнээ¹ /

Ц. ОЮУНТУЯА /5.0% хувьцаа эзэмшигч // эчнээ¹ /

HE SHANJUN /5.0% хувьцаа эзэмшигч // эчнээ¹ /

ХУРАЛ УДИРДСАН:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: П.Очирхуяг

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Т.БАЯРМАА

ХУРАЛД БАЙЛЦСАН:

1. He Jingwen / эчнээ¹ / /Гүйцэтгэх захирал /
2. Пүрвээ Очирхуяг /биечлэн/ /ТУЗ-н гишүүн/
3. Shih Pei Chin /биечлэн/ /ТУЗ-н хараат бус гишүүн/
4. Lin Yu-Fei /ТУЗ-н гишүүн/
5. Болд овогтой Отгонбаатар /биечлэн/ /ТУЗ-ийн гишүүн/

ТООЛЛОГЫН КОМИСС:

Б.БАТЦЭЦЭГ /дарга/

Э.АНХБАТ /гишүүн/

Эчнээ¹ - We Chat conference call



2020 ОНЫ 03 САРЫН 30

“ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ПРОТОКОЛ

2020 оны 03 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 03 дугаар сарын 30 -нд 15 дугаар хороо, Мандал хотхон, 42-11 тоотод 10:00 цагт хуралдав.

Дэлхий даяар COVID 19 тахал дэгдээд байгаатай холбоотой улс орон бүр хөл хорио тогтоож байгаа энэ үед Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр хийхийг зорих нь зүйтэй талаар зөвлөмж гаргасан тухай, Компанийн дүрмийн 7.2-т хувьцаа эзэмшигчид хуралд биечлэн болон цахим хэлбэрээр оролцож болно. Цахим хэлбэрээр гэдгийг “we chat video call” гэж ойлгоно гэж заасан байдаг талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б. Батцэцэг хурлын ирцийг бүртгэж, нийт 3 хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.6 хувийн ирцийг бүрдүүлж байгааг мэдэгдлээ.

Хурлын дарга П. Очирхуяг хурлыг нээж хүрэлцэн ирсэн хуралд оролцогчдод мэнд дэвшүүлэн хурлын дэгийг танилцууллаа. Уламжлал ёсоор гүйцэтгэх захирал He Jingwen орчуулга хийв.

- ❖ Компанийн өнгөрсөн жилийн үйл ажиллагааны талаар яриа эхэлж Компанийг шинээр зохион байгуулах ажилд хугацаа их зарцуулагдаж оны эцэст хүрсэн тул төлөвлөж байсан ажлууд хойшлогдож үйл ажиллагаа жигдрээгүй талаар ярилцлаа. ТУЗ-ийн гишүүд үйл ажиллагаа жигдэртэл цалин урамшуулалгүй ажиллана гэж дашрамд дурдав. Санхүүгийн байдлын хувьд 2019 онд хурал зохион байгуулахтай холбоотой зардлууд гарсныг алдагдлаар бүртгэснээс өөр үйл ажиллагаа явуулаагүй болохоор санхүүгийн тайланд төдийлөн өөрчлөлт ороогүй. Харин эздийн өмчийн хэсэгт дүрмээс зөрүүтэй хэсэг байсныг аудитын компанийн зөвлөмжийн дагуу засч, залруулж, тодруулга хийсэн, мөн өнгөрсөн оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангууд гарч холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулсан байгаа талаар мэдэгдэв. Бүгд хүлээн зөвшөөрч буй мэт аялга гаргалаа.
- ❖ Дараагийн хэлэлцэх асуудал болох ТУЗ-ийн дүгнэлт рүү яриа хөврөн оров. ТУЗ болон Компанийн гүйцэтгэх удирдлагын ажил гүйцэтгэлээс үл хамааран төлөвлөж байсан ажлууд бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг хүлээсээр хойшлогдсон. Үйл ажиллагаа идэвхигүй байсан нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлагатай хамааралгүй байна гэж дүгнэснийг, мөн Компанийн санхүүгийн тайлан ямар нэгэн

асуудалгүй, үйл ажиллагаагаа шинээр явуулахад бэлэн гэж үзсэн дүгнэлтийг санал нэгтэй зөвшөөрөв.

- ❖ Компанийн тухай хуульд зааснаар Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно гэсэн байдаг. Манай компанийн дүрмийн 7.40 дэх хэсэгт ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 жилийн хугацаатай сонгож болно гэж заасан байдаг талаар ТУЗ-ын нарийн бичгийн дарга дурдав. 2020 оны ээлжит энэ хурлаар өмнөх жилийн 11 сарын 18 ны өдөр сонгогдсон 9 гишүүнийг улируулан сонгож 3 жилийн хугацаатай томилох асуудлыг хэлэлцүүлэхээр ТУЗ шийдвэрлэснийг хэлээд ТУЗ-ийн гишүүдийг Хурлын дарга танилцуулав. Энэ асуудлыг дэмжиж байгаагаа хуралд оролцогсод илэрхийллээ.
- ❖ Өнгөрсөн жил төлөвлөсөн ажлууд хийгдэх бололцоогүй байсан тул энэ онд хэрэгжүүлэхээр Компанийн 2020 оны төлөвлөгөөнд тусгаж тогтоолын хавсралтаар оруулах талаар хурлын дарга хэлж, төлөвлөгөөг танилцуулав. Бүгд дэмжлээ.

Ингээд хурлын төгсгөлд Компанийн тухай хуулийн 46.8 дах хэсэгт заасан шалгуурыг хангаагүй буюу тайлант хугацаанд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар 2020 оны 2 дугаар сарын 14 ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн тогтоолыг танилцуулж, энэ хурлаар гарах тогтоолын төслийг Гүйцэтгэх захирал He Jingwen нийт гишүүдэд орчуулж өгч танилцуулав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА:



/П. ОЧИРХУЯГ/